

“ЦЭРЭНПИЛ” ДҮРСЛЭЛ

Д.Батжаргал*

* МУИС, НШУС, Утга зохиолын тэнхмийн багш, докторант

Түлхүүр үг: хөргийн дүр, хүний зан чанар, сайн дүрслэлийн гайхамшиг, сэтгэлд хоногших чанар.

Хүнийг дүрсэлнэ гэдэг нарийн урлаг шаардсан чимхлүүр ажил. Оновчгүй зураглаваас хэн нэгийг гомдоож сэтгэлд нь шарх үүсгэхээс гадна тэр хүнийхээ амьдралд шинэ хоч нэмж доог зугааны бай болгох аюултай. Нүдэнд харагдаж сэтгэлд буутал оновчтой сайн дүрсэлж гэмээ нь уулзаагүй атал “хайр хүрэм” дотносон, хүн гэдэг ийм л байдаг шүү дээ гэсэн бодолд өөрийн эрхгүй автуулна. Нүүр царайгий нь хараагүй атал уулзаад ярьсан мэт, сэтгэлд “суулгаж” өгнө гэдэг гарцаагүй сэтгүүлчийн ур чадвар. Ийм чадвар эзэмшсэн үгийн бурхад Монголын сэтгүүл зүйд цөөхөн төрсний нэг нь яах аргагүй Шагдарсүрэнгийн Цэрэнпил мөн.

Улс төрч, лам хувраг, урлаг соёлын одод, эгэл жирийн олон хүнийг үгийн цэцэн үзгийн хурцаар сийлж амьдралд мөнхлөн үлдээгээд өөрөө бурхны оронд оджээ.

Үзгээрээ сийлж үлдээсэн хүмүүсийн дотор “Хэнээт” Эрдэмбилэг, “Хачин” Даваажав, “Кант” Балдан гэдэг жигтэй адал сонин явдалтай, гэхдээ бодит,

эдүгээ бидний дунд ажиллаж амьдарч байгаа хүмүүс олон бий.

Манай сэтгүүл зүйн “байлдагч” нэгэн эрхмийн тухай дурсч үгүйлж сануулж бичсэн хөрөгтөө “Тэр бол манай чөлөөт сэтгүүл зүйд цахилан гарч ирээд хэл сураггүй болсон нэгэн билээ. Тэр бол өнөөгийн чөлөөт хэвлэл өнгө төрхөө олоход эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төлөвшилд өөрийн хувийг оруулчихаад явж одсон хачин хүн юм”¹ гэж түүнийг тоймлон тодорхойлоод “цахилан” гэдэг хүчтэй үгээ хэд хэдэн баримтаар яв цав баталсан юм. Тухайлбал, “Хүмүүс”, “Нөгөөдөр” зэрэг сонинуудыг үндэслэсэн, Зоригийн цогцсын өнгөт зургийг тавьж уншигчдыг хиртхийлгэсэн зэрэг баримтыг барин тавин өгүүлж Цагдаагийн хурандаа И.Цэдэн-Ишийн “С.Зоригийг алсан хэргийг Даваажав шиг мөшгөсөн сэтгүүлч байтугай цагдаа ч байхгүй. Тэр уг хэрэгт гайхалтай криминалистик хийсэн байдаг” гэсэн албаны чухал эх сурвалжийн үгээр баталгаажуулсан зэрэг нь үнэхээр бяр зааж бичдэгийг харуулж байна.

Цэрэнпил хүнийг дүрслэн зурахдаа гарамгай. Дээр өгүүлсэн Даваажавын хөрөг бичлэгтээ “Тэр толгойдоо гүнзгий гэмтэл авч хэсэг хугацаанд яльгүй

салгалж, долилзох болсон билээ” гэдэг ч юм уу, манай сэтгүүл зүй судлаачдын хараанд олонтаа өртсөн “Хэнээт” хөргийн Эрдэмбилэгийг уншсан номноосоо уур хүрч цагдаа нарыг доромжлон эрүүлжүүлэхэд баригдсаны дараа олон эрэгтэй дүү нар нь тохуурхан ярьж байгааг “Харин архайсан хэдэн эрэгтэй дүүд нь аав ээжийнхээ нүднээс далд өөр хоорондоо пар пар инээлдэн бие биенээ тохуутай ёврон байж “манай ариун явдалтан, их этикч, дээдийн сургаалаар биднийгээ гийгүүлэгч маань эрүүлжүүлэх гэдэг хачин газар орсон гэл үү, ха ха... Ингэхэд хөөрхий бид хэдээс тэр булай газарт очсон нь ер бий бил үү, арай тэгэж шившгээ тариагүй шиг санагдах юм, тийм байх аа, гэтэл мань хэд дотроос очиж очиж нөгөө ариун явдалтан маань ... ха ха” гэгцгээсэн гэдэг” гэж их л донжтой бичиж, үнэхээр тэдний дунд суугаа юм шиг, тохуурхлыг нь өөрөө сонсоод байгаа юм шиг үнэмшилтэй бичжээ. Залуусын бие биенээ цаашлуулахдаа, эсвэл хэн нэгнийг доромжлохдоо хэлдэг дунд насныхны үгийг гайхалтай олж шигтгэж өгсөн нь үнэнд ойртож хөргийг улам зугаатай уншууртай болгожээ.

Гэтэл манай ядуу үгтэй, нунж дорой бичлэгтэй зарим сэтгүүлч гаднаас нь өнгөцхөн дүгнэх, хэт хөөргөн магтах явдал бишгүй. Шинэ зууны босгон дээр манай сэтгүүлчид сонгуульд нэр дэвшигчдийг өөрийг нь өөрөөр магтуулсан, эсвэл нөхдөөр нь үнэлүүлэн “Онцгой чухал хүн”, “Төрийн төлөө төрсөн хүн”, “Монголын төр энэ хүнээр дутаж байна”, “Шударга бус удирдагчдаас айж эмээх, зусардан бялдуучлах, ая тал засах булчирхай түүнд огтоос хөгжөөгүй. Өнгө,

мөнгө, нам гуравт бөхийж үзээгүй” гэсэн хэт үзэл бодлоор дүгнэсэн, түүнийгээ нотлох баримтгүй цагаан магтаал зонхилсон нийтлэл хөргүүд бичиж байлаа. Ингэж илт долигنون бичих нь сонгогчдын дургүй хүргэж нэр дэвшигчдэд сөрөг PR болж болох юм. Бүр тодорхой хэлбэл “Баянгол дүүргийн 66 дугаар тойрогт нэр дэвшигчийг “Ардчиллын анхны сэтгэгчдийн нэг. МСДН-ын баримт бичгийн эх зохиогч, намынхаа улс төрийн бодлогыг тодорхойлогч” гэсэн бол 64 дугаар тойрогт нэр дэвшигчийн сурталчилгаанд “Хүндтэй сонголт тохиох болж. Түүнийг сонгох нь эрхэмсэг сонголт” гэж сүржигнэжээ. Мөн 66 дугаар тойрогт МБНН-аас нэр дэвшигчийн рекламд “Шударга үнэний төлөө ганц зүтгэгч, гэмт хэрэг, хээл хахуулийг илчлэгч”² гэх зэргээр нэг талыг хэт барьж магтсан жишээ олон байна

Харин Цэрэнпил агсан улс төрийн хүрээнийхнийг ч үнэнээр бичихийг гол болгоно. Улс төрч Ж.Бямбадоржийн тухай “Тэр угаас сэтгэлийн хөдлөл ихтэй аж. Энэ хөдлөл нь түүний шаргуу, сандчуу, бүтээлтэй ажиллах үндсэн хүч болдог байж мэднэ. Сэтгэл хөдлөл нь түүнийг цовоо хөнгөн уян элгэмсүү болгодог. Гаднаасаа Бямбадорж парламентач, улс төрч, тэр тусмаа хуульч гэмээргүй харагддаг. Харин хөнгөн жингийн бөх, боксчинтой төстэй”³ гэж зохиогчийн үзлээ харамгүй шингээн бичиж “цангинасан тод, шингэн дуу” гэхчлэн нүдэнд үзэгдэх төдийгүй сонсдох чанарыг илтгэн өгүүлсэн байна. Үүнд улс төрч гомдохгүй. Яагаад гэвэл шингэн цангинасан дуутай гэдэг үгээ зохиогч өөрөө ч бус эх сурвалжаар хэлүүлсэн нь бас л нэг бяцхан тактик.

“Хүн тоохын аргагүй уйтгартай хачин юмыг жигтэйхэн эвийг нь олоод гоё гүймхий болгочихно... Энэ зууны эхээр Пулитцер, Хёрст нар шинэ сэтгүүл зүй гэгчийг гаргаж ирэхдээ уран дүрслэл буюу хэл, сэтгэхүйг онцгой төвшинд авч үзэж байсан юм. Энэ шаардлагад Ш.Цэрэнпил тун ойртож очно”⁴ гэж доктор судлаач До.Цэнджав бичсэн байна. Тэрбээр зөвхөн хүнийг чадамгай дүрслэхээс гадна газар орны байршил, орчин тойрныг сайн “зурж” нэг үгээр хэлбэл үйл явдлын “дэвсгэр” юм үзэгдлийн цаг хугацааг уялдуулан логик холбоос сэжмийг нийцүүлэн тохируулна.

Төв аймгийн таван даргын тухай нэлээд дээр үед гаргасан номондоо нэг дарга нь оройхон харуй бүрийн үест халуун усанд орохоор явж байтал хүүхдийн гаслант уйлаан сонсдож байна. Дарга усанд орох бага “хэрэг”-ээсээ татгалзан тэнд очтол ямар зүйл угтсаныг ийн өгүүлжээ. “Харанхуй бохир хашааны голд яйжгар хар гэр. Нохой гангинан гасалж хуцна. Нөгөө гаслант уйлаан хар гэрээс гарч байв. Гэрийн бүслүүрээс урт дээс татсан нь сарны гэрэлд могой мэт ёргүй үзэгдэнэ”⁵ гэх мэтээр уран сайхны дүрслэлээр амьдруулж нэг л хэцүү газар ирснийг тун төвөггүй төсөөлүүлж байна. Мөн тэр үед гаргасан өөр нэг бүтээлдээ сүм хийдийн туурь малын хашаа болсон тухай дүрслэхдээ “Зузаан товхгор шивх хойгонд дарагдсан нойрмог дүнсгэр эл хуль, анир алдарсан ийн орчлон хэнийг

боловч хорвоогийн жамын тухай уйтгайхан бясалгалд автуулах хүч нөлөө агуулсан байх шиг санагддаг”⁶ гэжээ. Сонсогдох, үзэгдэх, мэдрэгдэх байдал бүрийг бүрэн дүрсэлдэгт сэтгүүлч Цэрэнпилийн дүрслэлийн хүч оршдог.

Бидний дээр дурдсан “Кант” хэмээх хочтой Балдан гэдэг урлагийн хүний тухай хөрөгт “Балдан заримдаа “Симба” хэмээх хүүхэлдэйн киноны цэцэн мэргэний модон таяг тулсан, арилсан сэтгэлт, өгөөмөр ач нөлөөт хөгшин сармагчин шиг харагддаг. Уолт Диснейн зөнөг донгио харагдах тэр сармагчин од эрхэс, нар сарны шидэт нөлөө сэлтийг ашиглан тэнгэрийн бошгыг тайлж амьтдын агуу ертөнцийг хэн эзэгнэн захирах учиртайг зөгнөн зааж,

«

*Нүүр царайгий нь хараагүй
атал уулзаад ярьсан мэт,
сэтгэлд “суулгаж” өгнө гэдэг
гарцаагүй сэтгүүлчийн ур
чадвар. Ийм чадвар эзэмшсэн
үгийн бурхад Монголын сэтгүүл
зүйд цоохон төрсний нэг нь яах
аргагүй Шагдарсүрэнгийн
Цэрэнпил мөн.*

»

мэргэн ухаанаараа ширэнгэн ой, хээр талд амар амгаланг тогтоон хамаг амьтныг жаргуулдаг. Төрөлх зөн совинт, байгалиас заяасан ухааны хишигт, язгуур сайт хэмээгчийн алсын нөлөө гэгээ ийм байдаг ажгуу” хэмээн баримт дээр чөлөөтэй хөрвөн, дэлхийн ертөнцийн содон сайн бүтээлийн баатартай хүртэл адилтган бичсэн нь зөвхөн авсан мэдээллийнхээ аяган дотор хутгалддаг бяд муутай сэтгүүлчдийн дэргэд ухааны царай том байгааг харуулж байна. “Симба”-гийн сармагчны зүйрлэлийн дараах залган өгүүлэх баримт нь бүр хүчтэй.

“Балдангийн дээд удмын тухай Амарбаясгалан хийдийн цорж лам Даваахүү

гуай хэмээх 90 барагласан настай лам “Энэ Балдангийн дээд таван үе нь манай хийдийн цорж ламаар тасралтгүй сууж байсан гэдэг. Би тэдгээр цорж нарын сүүлчийн хөгшин залуу хоёр цорж гуайг мэдэх юм. Залуу цорж лам бугай зуны өглөө эртээ босч гэр түшүүлж тавьсан уургаа барин адуундаа мордож, адуугаа цуглуулж ирчихээд хуралдаа суудагсан. Мөн ч эрдэм ухаан тэгшхэн, бас эрийн хийморьтой улс байсан даа” гэсэн ишлэл авсан нь ерийн нэг азай буурлын яриа бус лам нарын ховорхон байдаг сонин хүнийг өгүүлсэн байх жишээтэй. Адуугаа хурааж ирээд хуралдаа суудаг цорж тухайн үед хэр олон байсан гэж эрхгүй бодогдуулж байна.

Баримтаас баримт руу уншигчийг улам сонирхолтой хөтөлдөг нь бас нэгэн гайхамшиг. Бичих зүйлээ тархи оюундаа тунгаан бодож дүрсэлдэгийн жишээ. Төрийн өндөр алба хашиж хэсэгхэн хугацаанд Ерөнхий сайдын албыг хүртэл хашаад авсан Ш.Гунгаадорж Сэлэнгэ аймгийг толгойлж байхдаа Балданг “Сэлэнгийн долгио” чуулгын найруулагчаас авч хаясан хэсгийг дүрслэхдээ “Эрэгтэй жүжигчид нь хөл толгойгүй “савж”, эмэгтэйчүүд нь лалынхан оршуулганд оролцож буй мэт хэнгэнэтэл орилолдон гашуудлаа тайлж, намын хороог далдуур эсэргүүцсэн байна”⁷ гэж бичжээ.

“Хэнгэнэтэл орилолдон”, “...янгиуулан байж хачин чанга инээнэ” (“Үнэн ба Жа Пүрэв”), гэх мэт харагдуулан ард түмэнд ойр дөт аман зохиолын дүрслэгдэхүүн хэрэглэсэн нь оновчтой болсон байна. “Тогоо хангинатал чанга чанга инээх”, “манарч гөлрөх”, “хэнгэнэтэл санаа алдах” гэж хэлдэг сайхан

дүрслэлээр бүтээлээ баяжуулдаг нь түүний онцлог тал.

Профессор Л.Норовсүрэн “Бичсэн бүхэндээ онолын мэдлэг, мэргэжлийн төвшингээ харуулах, өөр үгээр хэлбэл “аксиомлог” бичихийг эрмэлздэг нь түүний бусдаас ялгарах онцлог” гэж хэлсэн бол “дүрслэн бичдэг нь түүний ур чадварын гойд онцлог” гэж хэлмээр байна. Үүнээс улбаалан Монголын нэртэй нийтлэлч, сэтгүүлчдийн бичлэгийн онцлог ур чадварыг нэршүүлэн судлах цаг болсныг эл бяцхан өгүүллээрээ дамжуулан хэлмээр байна. Хязгаар хярхаггүй сансрын уудамд тоо тоолшгүй оддоос нэгийг зүслэн тогтоосон эрдэмтэн тэр тэнгэрийн эрхэсийг “өмчлөн” өөрийн нэрээр нэршүүлэн илэрхийлдэг атал, хүний оюуны ертөнцийд од шиг гялалзах олон сайхан гэрэлт хөрөг нийтлэл бичсэн сэтгүүлчийн ур чадварыг дээдлэн дүрслэл бүтээлийг нь нэршүүлэн зааж болмоор. Тиймээс “Цэрэнпил” дүрслэл гэж зориуд нэрлэсний учир энэ.

Ишлэл

¹ “Өдрийн сонин”. 2005. №05.

² *Б а т ж а р г а л Д.* 2000. Сонгуулийн сурталчилгааны “шалгалтад” Монголын сэтгүүлчид унажээ // “Сэтгүүлч” сэтгүүл. №3.

³ “Ардын эрх”. 1995. № 225.

⁴ *Ц э н д ж а в Д о.* Мартамхай үлгэрч... // *Ц э р э н п и л Ш.* 2008. Хэнээт. УБ., 134 дэх тал.

⁵ *Ц э р э н п и л Ш.* 1996. Таван тавилан. УБ., 23 дахь тал.

⁶ *Ц э р э н п и л Ш.* 1995. Хутагтын тухай хууч. УБ., 16 дахь тал.

⁷ “Өдрийн сонин” 2004 № 12

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батжаргал Д. 2000. Сонгуулийн сурталчилгааны "шалгалтад" Монголын сэтгүүлчид унажээ // "Сэтгүүлч" сэтгүүл. №3.
2. Цэрэнпил Ш. 2008. Хэнээт. УБ.
3. Цэрэнпил Ш. 1996. Таван тавилан. УБ.
4. Цэрэнпил Ш. 1995. Хутагтын тухай хууч. УБ.
5. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тэмдэглэл. Гутгаар боть. УБ.

Resume

In this article, the author urges the need for a dedicated study on the characteristics and

skills of the writings by well-known Mongolian publicists and journalists, and promotes the author's recognition for their publications.

The astronaut, who surges the borderless infinities of the universe and gives his or her name to eternal bodies such as stars and universes, which have existed unnamed up to that point, whatsoever. However, the journalists, the so-called "inhabitants of the human world of thought and wisdom", do not enjoy the same privileges and settle for a miserable reference only. It's time to make a change. Why not, the works of any journalist could be known by author's name like any scholar holds his or her works by. Thus we intentionally came up with 'Tserenpil style'.